

**“MNS 5884:2016 Харилцаа холбооны цамхаг болон антенны суурь байгуулахад тавих ерөнхий шаардлага”
стандартын төсөлд ирүүлсэн саналуудыг тусгасан эсэх талаар тайлбар**

2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

№	Заалт	Төслийн эхний хувилбар	Саналын товч агуулга	Саналыг тусгасан эсэх	Тайлбар
1	1	Нэр томъёо, тодорхойлолт	Цамхагийн ачааллын дээд хэмжээ -гэсэн нэр томъёог нэмж оруулах, өөрөөр хэлбэл цамхагт байрлуулж болох овор хэмжээ, жин, цацаргалтын чадлын хэмжээгээр хамгийн их хэмжээг дурьдаж өгөх	Тусгах шаардлагагүй	Ямар цамхаг барилулахаас шалтгаалж өөр өөр байна. Цамхагт байрлуулах төхөөрөмжийн жингээс гадна цамхагийн хийцийн төрөл, овор хэмжээ, төмрийн орц, ажлын тавцангийн тоо болон нэг дор хэдэн хүн цамхагт ажиллах шаардлагатай зэргээс хамааруулан цамхагийн ачааллын хэмжээг салхины хүчний тооцоо, байгалийн давагдашгүй хүчин зүйл зэргийг тооцож, тусгай програмаар бодож тооцдог. Одоогийн байдлаар оператор компаниудын хувьд мэргэжлийн байгууллагаар хийлгэж баталгаажуулсан зургийн дагуу захиалдаг. Зураг хийлгэхдээ антенны тоо, төрөл, жин, нэмэлт хэрэгсэл (кабель, бусад даглдах жижиг антен), ажиллах хүн, нэмэлт төхөөрөмж байршуулах нөөц зэрэг үзүүлэлтүүдийг гаргаж өгдөг. Гэхдээ тухайн цамхаг эзэмшигч компани өөрийн зардлыг нөхөх, цаашдын бизнес төлөвлөгөөг тооцоолон нэмэх шаардлага байдаг. Стандартын 4.1-д “Шаардлагатай урьдчилсан судалгаа, дүгнэлтүүдийг холбогдох эрх бүхий байгууллагуудаар хийлгэх”, 5.2-д “Зураг төсөл боловсруулахдаа инженер геологийн судалгаанд үндэслэн хөрсний бүтэц, хөрсний ус, салхины хүч, газар хөдлөлт, мөстөлт зэргийг заавал тооцож цамхагийн динамик ачаалал (цамхагт байрлуулах, антен, фидер, салхины ачаалал), хэвтээ ба босоо тэнхлэгийн дагуу цамхагийн суурьт үүсэх ачаалал, даралтыг зөв тодорхойлсон байна.” Гэсэн заалтуудад санаа нь багтсан байгаа болно.
2	6.1.2	Ба-р зураг. Антенны баганан суурийн их бие, хүндрүүлэгч,	ПОЗ гэсэн үгийн монгол үгээр солих	Тусгасан	

		тэдгээрийн бэхэлгээний жишиг зураг			
3			Харилцан нөлөөллөөс сэргийлэх зорилгоор цамхагт байрлуулах өргөн нэвтрүүлэг, үүрэн холбооны антены байршлын өндрөөр зааж тусгаарлах Жишээ нь: “Өргөн нэвтрүүлгийн антенн хамгийн дээд тавцанд байрлана” гэх МЭТ	Тусгах шаардлагагүй	Стандарт нь цамхаг байгуулахад тавигдах шаардлага, хэм хэмжээг тодорхойлох учраас түүн дээр байрлах төхөөрөмжийн хийц загвар, харилцан нөлөөлөл гэх мэт нарийвчилсан зүйлийн хэм хэмжээг тодорхойлох ёсгүй. Цамхагт антенн байрлуулах-даа ижил буюу ойролцоо давтамжуудийн харилцан нөлөөллийг тооцоолж байрлуулах шаардлагатай. Онолын хувьд заавал дээд хэсэгт нь РӨН антенн байрлана гэсэн ойлголт байхгүй. Өргөн нэвтрүүлэг, үүрэн холбооны давтамжийн цараа, харилцан нөлөөлөл үүсэх эсэх талаар тухайн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс тооцоо судалгаа хийх, техникийн даалгавраар тодорхойлох шаардлагатай. <i>Стандартын 4.8.6-д “Харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэгч компаниудын хувьд техникийн болон радио давтамжийн хувьд өөр хоорондоо харилцан нөлөөлөл үүсэхээргүй байх тохиолдолд нэг байрлалд, нэг цамхаг ашиглах зарчмыг баримтлана.”</i> <i>4.8.7-д “Техникийн болон радио давтамжийн хувьд өөр хоорондоо харилцан нөлөөлөл үүсэхээр бол тухайн үйлчилгээ үзүүлэгч өөрийн цамхагийг байгуулах ба цамхаг хоорондын зай 3 м-ээс багагүй байна.” гэж заасан.</i>